



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 12

Арвайхээр

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРТ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлд:

“12.1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн дүн, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Салбар комиссын дарга Ц.Ганболд Зөвлөлийн гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт даалгав:

1. “Нийт ажилтан, албан хаагчдын сахилга, хариуцлага, ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах чиглэлээр байгууллага бүр үйл ажиллагаандаа улирал тутам хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод хяналтыг тогтмол хийх замаар үр дүнд хүрч ажиллах;

2. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, шинээр орсон алба хаагчдад ажлын дадлага олгох, туршлага судлуулах;

3. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд программ хангамж нэвтрүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

4. Баримт бичгийн боловсруулалт, хууль эрх зүйн үндэслэл, албан хэргийн стандарт, зааврын хэрэгжилтийг ханган, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хэрэгт хөтлөгдөх хугацаа дуусмагц байгууллагын архивт бүрэн бүрдэлтэй баримт шилжүүлэхийг нийт төрийн албан хаагчдад мөрдүүлэх;

5. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дүрэм, журмыг шинэчлэх, хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах;

6. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудыг орон тооны архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтантай болгох асуудлыг судлан шийдвэрлэж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгах;

7. Байгууллагын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, тусгай төрлийн баримтаар хэрэг бүрдүүлэн төрийн архивт хүлээлгэн өгөх ажлыг чанартай зохион байгуулж хэвшихийг Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.” гэжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

